

I. Монголын түүхийн онол-арга зүйн асуудлууд

ТҮҮХ, ТҮҮХИЙН САЛБАР УХААНУУДЫН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ АЖИЛ 60 ЖИЛД

Ж.Болдбаатар, Д.Түмэн, М.Зулькафиль, Л.Мөнх-Эрдэнэ
Монгол Улсын Их Сургууль. Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

Өгүүллийн товч утга: МУИС-ийн НШУС-ийн түүх, археологи-антропологи, угсаатан судлал, сэтгүүл зүйн салбарын өнгөрсөн 60 жилд хийсэн сургалт судалгааны ажлын гол үр дүнг тоймлон өгүүлсэн байна.

Түлхүүр үг: түүх, археологи, антропологи, угсаатан судлал, нийгэм-соёлын антропологи, сэтгүүл зүй, онол, арга зүй

Бид өнөөдөр МУИС-ийн НШУС тулгын чулуугаа тулж, гал голомтоо бадраасны нэгэн жарны ойг тэмдэглэж байна.

Манай сургуулийн ууган нь буюу өвөг нь түүхийн салбар болой. Энэ утгаар нь хэдхэн хоногийн өмнө Монгол оронд үндэсний дээд боловсролтой түүхч мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 60 жилийн ойг ёслон тэмдэглэсэн юм.

МУИС байгуулагдаад тав дахь жилийн нүүр үзэж байх үе 1974 оны II сарын 1-ний МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны тогтоолоор МУИС-д Нийгмийн ухааны факультет байгуулахаар заажээ. Тус факультетийн ууган салбар түүхийн салбарын ажлыг эрхлүүлэхээр 1947 оны IX сарын 17-ны өдрийн МУИС-ийн ректорын тушаал гарч, Түүхийн тэнхмийг байгуулан, эрхлэгчээр нь захирал Б.Ширэндэвийг хавсарган ажиллуулахаар томилжээ. Тус тэнхим түүхийн ангийн сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийн программыг боловсруулан, түүхийн салбарыг 15 оюутантай нээжээ. 1949 онд анхны төгсөлтөө хийжээ. Тэр цагаас хойш 47 дахь удаагаа төгсөлт хийж, дээд мэргэжилтэй 1300 гаруй түүхч мэргэжилтэн бэлтгэсэн байна.

МУИС-ийн түүхийн салбарыг төгсөгчид болон тус салбарт ажиллагсадаас Монгол Улсын Хөдөлмөрийн баатар хоёр, Ардын багш нэг, Гавъяат цолтон 16, ШУА-ийн жинхэнэ гишүүн буюу академич 6, түүхийн шинжлэх ухааны доктор 23, боловсролын доктор 106 төрсөн байна. Монгол Улсын түүхч эрдэмтэдийн 60 гаруй хувь нь МУИС-ийн түүхийн салбар төгсөгчид юм. 1990-ээд оноос хойш манай түүхчдээс УИХ-ын сонгууль бүрт 2-4 төгсөгчид сонгогдож, парламентын гишүүн болж ирснийг тэмдэглэхийн хамт манай төгсөгч Ө.Энхтүвшин 2000 оноос хойш Төрийн сайдын алба хашиж, эдүгээ БСШУ-ны сайдаар ажиллаж буйг бахархан тэмдэглэж байна. Зөвхөн сүүлийн арван жилд манай тэнхмийн багш нараас Д.Өлзийдолгор, Ж.Урангуа, Ц.Жамбалсүрэн нар түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг амжилттай хамгаалсан нь МУИС-ийн тэнхмүүд байтугай, бусад эрдэм шинжилгээний байгууллагуудын түүхэнд бараг гарч байгаагүй ололт юм.

Тус тэнхмийн профессор, багш нар сүүлийн арван жилд “Монгол улсын түүх” ийн таван боть зохиол, “Монгол улсын түүх” (түүх, онол арга зүйн асуудлууд), “Дэлхий дахины түүх” I, II боть туурвиж, 80 орчим нэгэн сэдэвт зохиол, ном, товхимол бичиж хэвлүүлжээ.

2003 оноос түүхийн салбарын гурван тэнхмийн професор, багш нарын хүчинд тулгуурлан судалгааны ажлыг нэгтгэн зангидах Түүхийн судалгааны хүрээлэн байгуулагдан ажиллаж байна. Одоо тус хүрээлэнгийн шугамаар “XX зууны Монголын түүхийн судалгаа, түүх бичлэг” сэдэвт төслийг хэрэгжүүлж дуусах шатандаа явж байна. Жил бүр эрдэм шинжилгээний “Түүх” сэтгүүл гаргадаг.

Эдүгээ эл сэтгүүл 6 удаа гараад байна. Түүхийн тэнхимд 10 гаруй докторант, 20 орчим магистрант суралцдаг.

Тус хүрээлэн, түүхийн тэнхим Английн Кембрижийн их сургууль, Японы Кокишукан их сургууль, Бельгийн чөлөөт их сургууль, Хөх хотын их сургууль, Улаан хадын их сургууль зэрэгтэй ажил төрлийн холбоотой ажиллаж байна.

МУИС-ийн Түүхийн салбар үүсэн байгуулагдсанаас хойш ололт, амжилт дүүрэн нэгэн жарныг үдэж, түүх шаштирын дараагийн хуудсыг нээж байна.

1990-ээд онд МУИС-ийн түүхийн салбар өргөжиж, хоёр охин тэнхмийг төрүүлсэн юм. Одоогийн Нийгэм-соёлын антропологийн тэнхим 1993 оноос угсаатан судлалын тэнхим нэртэй үүсч, өнгөрсөн хугацаанд тус мэргэжлээр 100 гаруй бакалавр, 20 гаруй магистр төгсөөд байна. Одоо тус тэнхимд 80 гаруй оюутан, 12 магистрант, 4 докторант суралцаж байна.

Уг тэнхим Монгол, Дотоод Азийн бүс нутгийн нийгэм, соёл, улс төр, шашин, үндэстэн угсаатны асуудал, зан заншил зэрэг олон асуудлаар нийгэм-соёлын антропологийн олон чиглэлээр судалгаа явуулдаг. Нийгэм-соёлын антропологийн тэнхимд нийгэм-соёлын антропологи, Монгол, Дотоод Ази судлалын арвин хөмрөг бүхий эрдэм шинжилгээний номын сантай. Тус номын санг байгуулахад Deutsche Forschungsgemeinschaft, Chinggis Khan Foundation, the Asia Foundation, and University of Cambridge зэрэг байгууллагуудын өгөөмөр хандив гол үүрэг гүйцэтгэсэн билээ. Мөн манай тэнхим Монголын соёлын эд өлгийн үзмэрүүд бүхий угсаатны зүйн сургалтын танхимтай.

Нийгэм-соёлын антропологийн тэнхим Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн (ННХ) Эрдмийн Тэтгэлэгийн Хөтөлбөрийн (ЭТХ) түнш тэнхим бөгөөд дөрвөн багш уг хөтөлбөрийн судлаач болой. 2007-2008 оны хичээлийн жилд тус тэнхим ЭТХ-ийн хүрээнд гадаадын хэд хэдэн эрдэмтэдийг урьж ажиллуулна. Зочин профессорууд тэнхмийн сургалтын хөтөлбөр, эрдэм шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэхэд туслах юм. Түүнчлэн энэ жилээс эхлэн энэ тэнхмийн хоёр багш ReSET-ээс (Багшлах ур чадварын бүс нутгийн семинар) зохион байгуулж буй “Төв Евроазид Антропологийг хөгжүүлэхүй” нэрт гурван жилийн хөтөлбөрт оролцох юм.

Тэнхмийн дэргэд нийгэм-соёлын антропологийн оюутнуудын “Соёл” клуб ажилладаг.

Дараагийн охин тэнхим бол 1995 онд байгуулагдсан Археологи-антропологийн тэнхим юм. Өнгөрсөн хугацаанд 9 удаагийн төгсөлтөөр 130 гаруй хүн тус салбарыг дүүргэсэн байна. Одоо тус салбарт 90 гаруй оюутан, 30 гаруй докторант, магистрант суралцдаг.

Тус тэнхим “Баруун Монгол”, “Дорнод Монгол” зэрэг төслийг хэрэгжүүлж, хоёр дахь төслийн хүрээнд XIII зууны язгууртны булш малтаж, ховор нандин олдворыг олсон нь тухайн үеийн түүхийн нарийн ширийнийг тодруулахад онцгой ач холбогдолтой болсон юм. Мөн Хүннүгийн үеийн түүхийг тодруулах археологи-антропологийн цогцолбор судалгаа хийж байна. Мөн Монголын эртний улсуудын хүн амын генетикийн судалгааг БНСУ-ын холбогдох газруудтай явуулж буй. Мэргэжлийн олон улсын сэтгүүл гаргадаг. Тус тэнхмийн профессор, багш нар Английн Кембрижийн их сургууль, АНУ-ын Аризоны их сургууль, Солонгосын Чун-Аны их сургууль, Канадын Торонтогийн их сургууль зэрэг сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Өнөөдрийн эрдмийн чуулганд түүх, түүхийн салбаруудын хүрээнд сэтгүүл зүйн салбарыг хамруулан илтгэж буй нь дараах учир холбогдолтой юм. Түүхийн ухаан голлон өнгөрснийг, сэтгүүл зүй нь ихэвчлэн өнөө үеийг бичиж тодруулж байдаг боловч, учиг баримтын болон уран үгийн ороог барьж, утгын чимгийг зохиролдуулах үйлсэд нэгэн үзүүрт сэтгэлийг барин зүтгэж байгаагаараа нийтлэг юм. Ялангуяа түүхийн ухаанд үйл явцыг зэрэгцэн судлах арга (синхронный метод)

эрхэмлэх болж буй өнөө үед сэтгүүлчид хожмын түүхийг тодруулах үнэтэй баримт үйлдэн дархлагсад бүлгээ.

1961 оны намар МУИС-ийн Хэл бичгийн факультетэд сэтгүүл зүйн тэнхим байгуулагдсанаас хойш 46 жил өнгөрчээ. Эл тэнхим эдүгээ 30 орчим профессор, багш докторант, магистрант, докторанттай, сэтгүүл зүйн-сургалт судалгааны төв болжээ. Эл хугацаанд тус сургуулийн бэлтгэсэн сэтгүүлчдийн дотроос Монгол Улсын Соёлын гавъяат зүтгэлтэн Н.Иштавхай, М.Зулькафиль, Төрийн шагналт, зохиолч, сэтгүүлч Д.Төрбат, УИХ-ын гишүүн, байнгын хорооны дарга Т.Ганди, профессор Х.Ислам, Л.Норовсүрэн зэрэг нэрт хүмүүс төрөн гарчээ.

Сэтгүүлчдийн салбар бакалавр, магистр бэлтгэх төдийгүй, сэтгүүл зүйгээр доктор (Ph.D)-ын сургалт явуулж буй манай улсын цорын ганц байгууллага юм. Сүүлийн 10 жилийн дотор манай багш нар 50 орчим нэг сэдэвт бүтээл, судалгааны ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлсний дотор Л.Норовсүрэнгийн бичсэн “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм” 3 боть, “Монголын нийтлэл” 3 боть бүтээл, М.Зулькафилийн “Сэтгүүл зүйн онолын үндэс” 2 дэвтэр сурах бичиг, “Сэтгүүл зүйн тайлбар толь”, М.Зулькафиль, Ч.Чойсамба нарын “Дэлхийн сэтгүүл зүйн түүх” 2 боть, “Сэтгүүлчийн ёс зүй”, Б.Болд-Эрдэнийн “Сонины дизайн” зэрэг сурах бичиг нь томоохон байр эзэлдэг. Өнөөдөр тус тэнхимийн багш нар их, дээд сургуульд судалдаг гол гол хичээлүүдийн сурах бичгийг үндсэндээ бэлтгэж дууссан гэж хэлж болно. Энэ бол манай эрдэмтэн багш нарын нөр их хөдөлмөр, хичээл зүтгэлийн үр дүн гэдгийг онцлон хэлбэл зохино.

Сэтгүүл зүйн тэнхимийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин, одоо АНУ-ын Миссурийн их сургууль, Москва, Эрхүүгийн их сургууль, Болгарын Софийн их сургууль, Өвөр Монголын ӨЗО-ны Үндэсний их сургууль болон Улаан хадын их сургуультай байнгын харилцан холбоотой ажиллаж байна.

Бидний илтгэлд хамрагдсан салбаруудад Монголын урьдаа барьдаг нэрт эрдэмтэд академич Б.Ширэндэв, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, Ш.Бира, Ч.Далай, профессор С.Пүрэвжав, М.Санждорж, Г.Сүхбаатар, Э.Чимэдцэрэн, Ц.Санжаасүрэн, Х.Нямбуу, Г.Дэлэг зэрэг хүмүүс багшилж байсныг бахархан тэмдэглэж байна. Эдүгээ ч профессор академич С.Норовсамбуу, Д.Хүүхэнбаатар, Д.Наваан, З.Баасанжав, М.Зулькафиль, Ц.Жамбалсүрэн, Д.Түмэн, Г.Цэрэнханд нарын зэрэг нэртэй эрдэмтэд багшилж байна.

Түүх бол хүн төрөлхтний амьдралыг өнгөрсөн, эдүгээ, ирээдүй гурван цагийн хэлхээ холбоонд нь авч судалж, хэн хүний амьдралын ухаарлыг хөглөдөг шинжлэх ухаан юм. Товчоор хэлбэл, амьдралын тухай шинжлэх ухаан болой. Та улс Монголынхоо гал голомтыг ямагт бадрааж, ухаалаг аз жаргалтай байхыг хүсвэл өнгөрснөөс сургамж авч, өнөөгөө танин мэдэж, ирээдүйдээ өөдрөг чигч бодолтой амьдарч, хичээнгүйлэн зүтгэгтүн!

Монгол оронд үндэсний дээд боловсролтой түүхч мэргэжилтэн бэлтгэж эхэлсний болон НШУС-ийн нэгэн жарны ойг тохиолдуулан, бие эрүүл, ухаан саруул, үйлс өөдрөг, амьдрал хангалуун, түүх гэгээн, ид хав нэвт байхын өлзийт ерөөлийг өргөн дэвшүүлье.

Abstract: The article depicts the brief account of the evolution and development of the research capability and academic performance of the Departments of History, Archaeology-Anthropology, Socio-Cultural Anthropology, and Journalism of the National University of Mongolia School of Social Sciences during the past 60 years.